



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/161

Улаанбаатар хот

Нэгдсэн арга хэмжээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.4 дэх заалт, 24.6 дахь хэсэг, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.30.3 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.6.7, 31.6.10 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1024 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, мал амьтны гаралтай гоц халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд Нийслэлийн төвийн 6 дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малыг тууж гаргах, хашаанд саатуулах, хуулийн дагуу хариуцлага тооцох нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Дүүргүүдэд ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу нэгдсэн арга хэмжээг хамтран зохион байгуулахыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгууллагын удирдлага нарт, хориглосон бүс рүү малаа нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Э.Товуудорж)-т, Дүүргийн дэд Ажлын хэсэг болон харьяа дэргэдэх Газар, Нэгж, Хороодыг татан оролцуулж, тушаалын хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг дүүргийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж ажиллахыг Дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний газар (Ж.Дуламсүрэн)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Г.БАТЗОРИГ



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
А/16 тушаалын нэгдүгээр хавсралт

НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний газрын дарга
Гишүүд:	Нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Нийслэлийн Байгаль орчны газрын дарга Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга (Зөвшилцсөнөөр) Төвийн 6 дүүргийн Менежерүүд Дүүргүүдийн Теле камерын хяналтын дэд төвүүдийн удирдлага
Нарийн бичиг:	Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хорио цээр, баталгаажуулалт, хяналтын Хэлтсийн дарга Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалан, мал аж ахуйн Хэлтсийн дарга

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
11/161 тушаалын хоёрдугаар хавсралт

НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ДҮҮРГҮҮДЭД АЖИЛЛАХ ХУВААРЬ

Зохион байгуулагч: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

Хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл буюу Лхагва, Пүрэв, Баасан гарагийн 09:00 цагаас 18:00 цагийн хооронд арга хэмжээг зохион байгуулна.

Чиглэл: Дүүргийн маршрут, ажлын зургийн дагуу

Хариуцах байгууллага: Нийслэлийн Мал эмнэлгийн газар
Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар

Зорилго: НИТХ-ын 2024 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай” 09 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1024 дугаар захирамж болон Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 10 дугаар сарын өдрийн дугаар тушаалын хүрээнд төвийн 6 дүүрэгт Нийслэлийн хүн амын эрүүл аюулгүй байдлыг хангах зорилгоор нэгдсэн самналтаар хориглосон бүсэд нэвтэрсэн малыг тууж гаргах, хашаанд саатуулах, хуулийн дагуу арга хэмжээ авах

Хүн хүч: Дүүргийн дэд ажлын хэсэг, хороодын ажлын албаны ажилтан албан хаагчид оролцоно.

Д/Д	Дүүргүүд	Хариуцан ажиллах байгууллага	Удирдлага, мэдээллээр хангах албан тушаалтан
1	2	3	4
1	Баянзүрх Хан-Уул	Нийслэлийн Мал эмнэлгийн газар	Б. Цолмон 99195204 Э.Цогбадрал 99042197 Ц.Гомбосүрэн 99108337 Ц.Эрдэнэбаатар 99999883
		Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	
		Мэдээ тайлан нэгтгэл: НМЭГ Х.Нямбаатар 88885878	
2	Сүхбаатар Чингэлтэй	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Н.Отгонбаяр 88001139 Н.Мөнхбаяр 88117801 Э.Чинзориг 99193972 Л.Цэеэрэгзэн 88111557
		Нийслэлийн Байгаль орчны газар	
		Мэдээ тайлан нэгтгэл: НХХААГ Л.Бадамханд 88089412	
3	Сонгинохайрхан Баянгол	Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар	Э.Товуудорж 99196922 Г.Галбадрах 91114427 Д.Баярсайхан 89090090 Ж.Баатар 99084179
		Нийслэлийн Онцгой байдлын газар	
		Мэдээ тайлан нэгтгэл: НЦУГ В.Даваадорж 99056216	

Анхаарах зүйлс:

- Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хашааг байнгын эзэнтэй байлгах, жижүүрлэх
- Хашаанд мал хонох тохиолдолд өвс, тэжээлийн бэлэн байдлыг хангах
- Теле камерын хяналтын дэд төв болон дрон нисгэж ажиллах
- Дүүргийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Нэгдсэн арга хэмжээг сурталчлах

Тайлан мэдээг загвар хүснэгтийн дагуу өдөр бүр 17:30 цагт Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 70140424 дугаарт холбогдон өгөх



משרד הבריאות
מנהל בטיחות המזון
מנהל בטיחות המזון
מנהל בטיחות המזון

המנהל/ת מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

12. מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

12. מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

12. מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון

מנהל בטיחות המזון (מנהל בטיחות המזון) - 4. מנהל בטיחות המזון